ТҮҮНТЭЙ ХЭРХЭН НӨХӨРЛӨХ ВЭ?

НОХОЙГ АРЧЛАХ, ТҮҮНД ХАЗУУЛАХААС СЭРГИЙЛЭХ ХӨТӨЧ

Developed by:
René Grobler, Amanda Klette,
Netcare Trauma Division
Daniel Stewart & Terence Scott
Global Alliance for Rabies Control

WHO/HTM/NTD/NZD/2015.6

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

© World Health Organization 2015. All rights reserved.

НОХОЙН ХЭЛ

НОХОЙН ҮЙЛ ХӨДЛӨЛИЙГ ХЭРХЭН ОЙЛГОХ ВЭ?

ТҮГШСЭН

СЭЖИГЛЭСЭН

АЙСАН

ЗАНАЛХИЙЛСЭН

УУРЛАСАН

НАЙРСАГ

БАЧИМДСАН
(ОРОН ЗАЙ ДУТАГДСАН)

ЭРХЛЭХИЙГ ХҮССЭН

ХАЛУУЦСАН

ОТОХ, МЯРААХ
(ЯМАР НЭГ ЗҮЙЛИЙН ҮНЭР АВСАН)

САЙН УУ, БИ ЧАМД ХАЙРТАЙ

ТОГЛОХЫГ ХҮСЭЖ
БАЙНА

ТОГЛОХОД БЭЛЭН

ӨЛССӨН

ХӨӨРЧ ДОГДОЛСОН

© 2011 Lili Chin www.doggiedrawings.net

lili

Дэлхийн Эрүүл
Мэндийн
Байгууллага

ЗООНОЗЫН
ӨВЧИН СУДЛААЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Нохойтой харьцахад ХОРИГЛОХ үйлдлүүд

Энэ нь тун энгийн, хүмүүс хоорондын харилцаатай адил байдаг.

Бусдын хоолыг зөвшөөрөлгүй авах.			Нохой хоолондоо маш харам байдаг.
Бусдын тоглоомыг зөвшөөрөлгүй авах.			Нохойн аливаа эд зүйлийг авах.
Бусад руу удаанаар ширтэх.			Нохой руу ширтэх.
Унтаж буй хүнийг сэрээх.			Амарч буй нохойг оролдохгүй байх.
Бусдыг оролдож, залхаах.			Нохойн сүүл, чихэнд хамаагүй хүрэх.
Бусдын өвөр рүү авирах.			Нуруун дээр нь суух.
Бусдыг чимхэх, биенд хүрэх.			Нохой тэврүүлэх маш дургүй.
Бусад руу хашгирч, орилох.			Нохойн дэргэд хашгирч орилох, ямар нэг чанга дуу гаргах.

Poster adapted from resources available by Dr. Sophia Yin at www.drsophiayin.com

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДАЛЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Өнгөөр ялган будаарай



Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДАЛЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

НОХОЙН ЭЗНИЙ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА
ЗААВАЛ ЭДЛҮҮЛЭХ 5 ЭРХ

Энэ бол амьтан тэжээгсэд бүрийн заавал биелүүлэх хариуцлага:

1. Эрүүл хоол, цэвэр усаар тэжээх

2. Тав тухтай үүртэй байлгах

3. Өвдөж, гэмтсэн үед нь эмчлэх



4. Бусад эрүүл амьтадтай тоглуулж, нөхөрлүүлэх

5. Амьтдыг айдас, зовинолгүй, хөгжилтэй байлгах

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

УНТАЖ БУЙ НОХОЙГ ХЭЗЭЭ Ч БҮҮ ОРОЛД

Хөгжилтэй нөхөрлөлийг бий болгоорой.

Нохой тэжээнэ гэдэг маш том үүрэг, хариуцлага. Чиний нохой танай гэр бүлийн нэг гишүүн юм. Түүнтэй нөхөрсөг дотно харьцаарай. Тэд итгэж болох хамгийн үнэнч нөхөр юм.

Амьтадтай нөхөрсөг, эелдэг харьцах ёстой.

Нохойн сайн сургуулийн тусламжтайгаар, нохойг ойр зуурын даалгавар гүйцэтгүүлж сургадаг.

Нохойн сайн найз байхын тулд өөрийгөө бэлтгэх нь чухал юм.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН УНДЭСНИЙ ТӨВ

ХООЛНЫ ЗӨВ ДЭГЛЭМ БА ЦЭВЭР УС

Бид өөрсдийн хоолтой адилаар тэдний хоолыг шим тэжээл, амин дэм, эрдэс бодис, уураг кальци бүхий баялаг байлгах хэрэгтэй.

Өгч болох ба болохгүй хоол:

Болно	Болохгүй
Гүйцэд болгосон мах, махан бүтээгдэхүүн ✓	Шоколад ✗
Тахианы мах ✓	Усан үзэм ✗
Загасны ясгүй мах ✓	Сонгино ✗
Хүнсний ногоо ✓	Кофе ✗
Эслэг ба үр тариа ✓	Саримс ✗
Амтлаг төмс ✓	Бохь ✗
	Согтууруулах ундаа ✗

НОХОЙГ ЗААВАЛ ХАМРУУЛАХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНҮҮД

Нохдыг аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх боломжтой!

Үүний тулд зайлшгүй хамруулах эрүүл мэндийн үйлчилгээнүүд чухал юм.

Үүнд: **Жил бүр вакцинжуулах**
Улирал бүр туулгажуулах
Жил бүр мал эмнэлэгт үзүүлж, шинжлүүлэх

Нохойн эрүүл мэндийг байнга анхаарч, жил бүр мал эмнэлэгт үзүүлэх хэрэгтэй. Нохой тань эрүүл байснаар та болон танай гэр бүл эрүүл байна.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДАЛЛЫН УНДЭСНИЙ ТӨВ

WORD SEARCH

R	B	D	K	T	Q	P	L	A	Y	X	A	L	P	S
U	P	D	O	G	X	A	S	D	H	F	U	O	I	N
N	B	J	M	N	T	I	O	R	E	P	E	T	T	I
R	D	X	U	B	Q	Y	D	K	P	R	U	P	B	F
B	H	U	B	O	A	L	D	F	A	X	C	V	M	F
A	T	I	U	N	W	O	Z	W	N	D	I	O	P	S
R	G	W	W	E	B	V	Y	I	T	R	B	A	L	L
K	Z	A	O	Q	V	E	T	G	O	O	R	E	W	Y
Y	I	L	X	C	V	B	N	M	H	O	U	I	O	G
P	O	K	I	P	U	P	P	Y	U	L	T	T	H	B
A	S	D	F	H	F	J	H	K	Z	B	E	A	R	S
D	W	A	G	W	E	Y	T	Y	F	A	M	I	L	Y
Q	O	P	C	B	M	S	Z	C	X	V	R	L	E	W
T	O	Y	S	Z	V	B	W	D	T	Y	I	L	S	P
E	T	U	I	K	F	U	R	C	B	L	E	A	S	H

BALL
BARK
BONE
DOG
DROOL
FAMILY
FUR
LEASH
LOVE
PANT
PET
PLAY
PUPPY
RUN
SNIFF
TAIL
TOYS
VET
WAG
WALK

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛААЛЫН УНДЭСНИЙ ТӨВ

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ

Нохой хэн нэгнийг хазах нь буруу гэдгийг ойлгодоггүй. Тэд айсан буюу өөрийгөө хамгаалах тохиолдолд л бусдыг хаздаг. Нохойн зан төрхийг сайн мэдсэнээр түүнд хазуулахаас сэргийлж болно. Үүний тулд:

- Нохойн үзүүлж буй үйлдлүүдийн шалтгааныг мэддэг байх
- Түүнд хэрхэн аюулгүйгээр ойртох
- Хэзээ түүнтэй харьцахад аюулгүй байх вэ гэдгийг мэддэг байх хэрэгтэй.

Нохойн зан төрхийг мэдсэнээр түүнд хазуулах аюултай нөхцөл байдлаас сэргийлж болно.

БОЛЗОШГҮЙ ШИНЖ ТЭМДГҮҮД:

- БИЕЭ ХУРААХ
- СҮҮЛЭЭ БОСГОХ
- ЧИХЭЭ ХУЛМАЙЛГАХ
- УХАРЧ, ЗАЙМРАХ
- АРХИРАХ
- ДАЙРАХ ШИНЖТЭЙ БОЛОХ
- УДААНААР ШИРТЭХ
- ҮС НЬ БОСОХ

ЭНЭ ҮЕД ЯАХ ЁСТОЙ ВЭ? ✓

- ГАРАА БИЕДЭЭ НААХ
- ХӨДӨЛГӨӨНГҮЙ ЗОГСОХ

ЮУ ХИЙЖ БОЛОХГҮЙ ВЭ? ✗

- ЗУГАТАХ, ГҮЙХ
- ХАШГИРАХ, ЦОЧИРДОХ
- ХАРАА САЛГАХ, АНХААРАЛ АЛДАХ

ХЭРВЭЭ ТА НЭГЭНТ ХАЗУУЛСАН БОЛ:

- ТҮҮНЭЭС ЗУГТАЖ БОЛОХГҮЙ
- ХӨДӨЛГӨӨНГҮЙ БАЙХ ХЭРЭГТЭЙ
- ХЭРВЭЭ ГАЗАР УНАСАН БОЛ ГАР, ХӨЛӨӨ ХУМИН АТИРЧ ХЭВТЭХ ХЭРЭГТЭЙ

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

ХАЗУУЛАХААС СЭРГИЙЛЭХ НЬ

Нохойд хазуулахаас хэрхэн сэргийлэх вэ?

Бидний мэдэх нохой:/өөрийн нохойтойгоо харьцахдаа/

Нохойг гөлөг байхаас нь байнга хамт тоглож, найрсаг харьцсанаар тэд хүнээс айх айдасгүй болно. Ингэж өссөн нохой хүн хаздаггүй, нөхөрсөг зан төрхтэй болдог. Энэ бол нохой тэжээдэг хүн бүрийн мэдвэл зохих үүрэг хариуцлага юм.

Нохой тэжээдэг хүн бүр нохойгоо ингэж өсгөж чадвал бидний амьдарч буй орчин тайван амгалан, аюулгүй байх болно.

Нохойгоо хөнгөлөхийг зөвлөж байна. Хөнгөлүүлээгүй эр ноход илүү догшин, хүн болон бусад амьтад руу дайрах магадлал өндөр байдаг. Харин эм ноход янз бүрийн өвчин тусах нь илүү байдаг.

Бидний мэдэхгүй нохой:/Танихгүй нохойтой харьцахдаа/

Хэрвээ үл таних нохой тань руу чиглэн ирвэл хөдөлгөөнгүй, дуугүй зогсох хэрэгтэй. Тэр таныг хэсэг хугацаанд үнэрлээд сонирхол нь буурч орхин явахад чимээгүйхэн, зөөлөн хөдөлж түүний эсрэг зүг яваарай.

Танихгүй нохдоос аль болох хол байгаарай. Үүнд уяатай болон хашаан дахь ноход ч хамаарна.

Танихгүй нохдыг шоглох, хөөх, түүнрүү юм шидэхийг хориглоно. Унтах, хооллох, үр зулзага /гөлгөө/-аа асрах үед нь амгалан тайван байдлыг нь хэзээ ч бүү алдагдуул.

Чиний байгаа орчинд нохой байгаа эсэхэд анхаарч байгаарай. Тэдэнтэй найрсаг байж, тэдний байгаа орчинд хүндэтгэлтэй хандана уу.

Нохойг ад үзэх, тэдэнтэй муухай харьцсанаар та өөрийн амьдарч буй орчныг улам бүр таагүй болгоно.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

ГАЛЗУУ ӨВЧИН ГЭЖ ЮУ ВЭ?

Галзуу өвчин бол вирусээр үүсгэгддэг, ихэнх хөхтөн амьтад ялангуяа ноход ихээр өвчилдөг. Өвчилсөн амьтдын шүлсэнд галзуугийн вирус агуулагддаг ба хазах, шүлсдэх үед шархаар дамжин эрүүл амьтад халдварладаг. Хэрвээ яаралтай эмнэлгийн тусламж авахгүй бол үхнэ.

Бид өөрсдийн амьтдаа галзуу өвчний эсрэг вакцинд хамруулснаар энэ аюулт өвчнөөс урьдчилан сэргийлж чадна.

Хазуулахаас сэргийлэх.

Золбин ноход зайлсхийх.

Самардуулах болон долоолгохоос болгоомжлох

ГАЛЗУУ ӨВЧНИЙГ ЭМЧИЛЖ БОЛОХ УУ?

Вакцин хийлгэснээр галзуу өвчнөөс урьдчилан сэргийлнэ. Өвчний шинж тэмдэг нэгэнт илэрвэл эмчлэх боломжгүй.

Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх 3 энгийн арга:

1. Аливаа амьтдад хазуулахаас сэргийлэх
2. Нэгэнт хазуулсан бол шархыг урсгал усаар 15 минутын турш хөөсрүүлэн угаах
3. Хэрвээ чи хазуулсан бол ахмад хүмүүст хэлж, яаралтай эмнэлгийн байгууллагад хандан, вакцин хийлгээрэй.

САНАМЖ:

Хэрвээ ахмад хүн олдохгүй бол найзтайгаа хамт өөрт хамгийн ойрын эмнэлгийн байгууллагад яаралтай хандаарай.

Галзуу өвчинтэй холбоотой асуулт, хүсэлт байвал дараах сайтад хандаарай: www.rabiesalliance.org

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨВ

13 ялгааг олоорой





Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨВ

ЗООНОЗЫН
ӨВЧИН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨВ

ГАЛЗУУ ӨВЧНИЙ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ!

Хэрвээ чи нохойд хазуулбал шархыг сайтар угааж, эмнэлэгт яаралтай хандаарай.

Нохойд хазуулахаас хэрхэн сэргийлэх вэ!

- ✕ Танихгүй нохойноос зайлсхий
- ✕ Зүй бус авирлаж буй нохойноос зайлсхий
- ✕ Нохдыг хөөж түүх, өшиглөх, цохих, хажуу нь чанга хашгирахыг цээрлэ
- ✕ Нохойг хооллох, унтах болон гөлөгнүүдтэйгээ байгаа үед бүү үймүүл.

agriculture, environmental affairs & rural development

Concept by: D. Stewart Rabies Project Designed by D.Cooke Department of Agriculture, Environmental Affairs & Rural development: Veterinary Epidemiology Section 033 3476267



Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨВ

ЗООНОЗЫН
ӨВЧИН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨВ

ТАЛАРХАЛ

Нохойтой хэрхэн зөв харьцахыг мэддэг болсон тул энэхүү батламжийг олгов.

Би
- Нохойтой болохоосоо өмнө заавал судлах
- Нохойд нүүрээ ойртуулахгүй байх
- Нохой над руу дөхөж ирвэл мод лугаа хөдөлгөөнгүй зогсох
- Нохойг хооллох, унтах болон гөлөгнүүдтэйгээ байгаа үед үймүүлэхгүй байхыг амлаж байна.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛААЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ